

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Хөдөлмөрийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Монгол Улсын Далайн захиргаа

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

-

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд А.Амарын гудамж, Лагшан төв

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, Байгууллагын зорилт, чиг үүргийг холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, тайлагнах, удирдлагыг мэргэжил арга зүйн дэмжлэг, мэдээллээр хангах, хэлтсийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, гүйцэтгэлийн үр дүнг байгууллагын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны хэтийн болон ойрын стратеги төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх механизмд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, тайлагнах;
- 2.Удирдах дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, тайлагнах;
- 3.Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах;
- 4.Байгууллагын дотоод ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, тогтмолжуулж, үйл ажиллагааг сайжруулах, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах;
- 5.Санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хууль, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;
- 6.Байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалтыг хангаж ажиллах;

7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
8.Хууль тогтоомжид заасан бусад.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын хэтийн болон ойрын стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангуулан ажиллах; 2.Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг албаны ахлах мэргэжилтэн нартай хамтран боловсруулах, санал авах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр нэгтгэн хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллах; 3.Даргын удирдлаган доор шийдвэр гаргах, стратегийн болон урт хугацааны бодлого, салбарын үйл ажиллагаа, зохион байгуулалт, удирдлага бүтэц, бүрэлдэхүүнийг боловсронгуй болгохтой холбогдсон асуудлаар мэргэжилтнүүдийг мэргэшлийн, цаг үеэ олсон зөвлөгөө, зөвлөмжөөр шуурхай хангах.	Байгууллагын үйл ажиллагаа жигд, тасралтгүй хэвийн явагдана.	Т,Г,Х,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын хэмжээнд удирдах дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах ажлыг зохион байгуулах; 2.Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр дээд газраас батлагдсан удирдамж, төлөвлөгөө, аудитын дүгнэлтийн хүрээнд холбогдох арга хэмжээ авч тайлагнах; 3.Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр яаралтай мэдээ, мэдээллийг боловсруулах ажлыг зохион байгуулах, хянах, тайлагнах;	Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналт сайжирна.	Т,Г,Х,Ш

	4.Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр яаралтай мэдээ, мэдээллийг боловсруулах ажлыг зохион байгуулах, хянах, тайлагнах.		
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын дүрэм, хөдлөмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм болон байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр мөрдөн ажиллах, журам, зааврыг шинэчлэх, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;	Байгууллагын хэмжээнд сахилга хариуцлага, дэг журам сайжирна.	Т,Г,Х,Ш
	2.Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн сахилга, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалтад хяналт тавих, цагийн тооцоог хянаж баталгаажуулах ажлын 3 хоног хүртэлх захиргааны чөлөөг чөлөөний хуудсаар олгох;		
	3.Даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах.		
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хэлтсийн ажлыг 7 хоног, улирал, хагас бүтэн жилээр төлөвлөн, тайлагнаж, өдөр тутмын үйл ажиллагааны уялдааг хангах, ажлын ачаалал, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж, ажилтан бүрийн ажлын бүтээмжийг сайжруулах ажилд хяналт тавих, үнэлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны жигд, тасралтгүй хэвийн явагдана.	Г,Х
	2.Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн албан бичиг өргөдөл гомдол, санал хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэж байгаад хяналт тавих, тайлагнах;		Г,Х
	3.Байгууллагын дүрэм, дотоод журам болон бусад эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;		Г,Х
	4.Удирдлагыг эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллээр ханган мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;		Г
	5.Байгууллагын дотоод ажлын уялдаа холбоог сайжруулах, хэлтэс, албаны ажлын батлагдсан төлөвлөгөөтэй сар бүр танилцан, биелэлтэд хяналт тавих;		


	6.Хэлтсийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, ажлын байрыг хувийн ашиг сонирхол болгохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг өгөх;		
	7.Хариуцсан ажлын чиглэлээр баримт материалуудыг архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах;		
	8.Салбарын үйл ажиллагааг сурталчлах, хийгдэж буй ажлуудын үр дүн, ач холбогдлыг олон нийтэд таниулж ажиллах.	Салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан байна.	Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах;	Санхүүгийн үйл ажиллагаа Шилэн дансны хууль хэрэгжиж мэдээллийн ил тод байдал сайжирна.	Т,Г,Х,Ш
	2.Байгууллагын хэмжээнд шаардлагатай техник тоног төхөөрөмж, бараа материалын хэрэгцээг тодорхойлж хангах ажлыг зохион байгуулах;		
	3.Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.		
6 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын бүтцийг оновчтой болгох, албан тушаалын ажлын байрны чиг үүргийн уялдааг хангах, давхардлыг арилгах, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах.	Цомхон, чадварлаг бүтэц бий болж, хүний нөөцийн чадавхи дээшилсэн байна.	Т,Г,Х,Ш
7 дугаар зорилтын хүрээнд	1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох;		Т,Г,Х,Ш
	2.Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах талаар санал боловсруулах, холбогдох сургалтад хамрагдах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ажилтнуудаа манлайлан ажиллах;		

	3.Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгахад ХАБЭА хариуцсан мэргэжилтэн болон үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажлыг чиглүүлэхэд анхаарч тэднийг удирдлага арга зүйгээр ханган ажиллах; 4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3, 28 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон ХАБЭА хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллах; 5.Албаны мэргэжилтнүүд холбогдох ажилтнууд ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж байгаад хяналт тавихаас гадна шаардлагатай зааварчилгааг тогтмол өгч хэвшүүлэх; 6.“Далайн захиргааны хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Эрх зүй /042101/, Олон Улсын харилцаа /031202/		
Мэргэшил	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад тэнцсэн байх		
Туршлага	Мэргэжлээрээ 5-с доошгүй жил ажилласан байх		
	Дүн шинжилгээ хийх	-Салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; -Салбарын чиглэлийн судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан санал, бодлогын зөвлөмж боловсруулах; -Албан үүргээ гүйцэтгэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.	
	Асуудал шийдвэрлэх	-Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; -Албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох	

Ур чадвар		-Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; -Өгсөн мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөнийхөө үндэслэл, үнэн зөв байдлыг хариуцах; -Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу зам, тээврийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; -Бусад.
	Багаар ажиллах	-Өөрийн мэргэжлийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох, эерэг уур амьсгал бүрдүүлэх; -Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд хамт олноо манлайлах; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Баг, хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; -Байгууллага, хэлтсийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиглэлээр баг, хамт олонтой хамтарч ажиллах; -Өөрийн үйл ажиллагаанд шинэлэг санааг нэвтрүүлэх, бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; -Саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;
	Бусад	-Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -Мэдээллийн орчин үеийн технологийг ашиглах, шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх; -Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; -Зам, тээврийн салбарын өөрчлөлт, шинэчлэлтийг нэвтрүүлэх, салбарын хэмжээнд зохион байгуулах мэдлэг, чадвартай байх; -Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байдлаараа манлайлах -Бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; -Харилцааны соёлтой, ёс зүйтэй байх; -Хамт олны саналыг сонсох, санал солилцох, эргэх холбоотой байх; -Бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Далайн захиргааны дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Хууль тогтоомж хариуцсан ахлах мэргэжилтэн	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: -Далайн тээвэр, хуурай боомтын хэлтсийн дарга; -Хөлөг онгоц, усан замын тээврийн бүртгэл хяналтын хэлтсийн дарга; -Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны дарга; -Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын албаны дарга;	Бусад харилцах субъект: 1.Зам, тээврийн яам; 2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс; 3.Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;

-Хэлтэс болон албаны ахлах мэргэжилтэн; -Хэлтэс болон албаны мэргэжилтэн; -Жолооч, гэрээт ажилтан.	4.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага; 5.Бусад.
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Т.МӨНХБАЯР (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20 ²⁵ оны 03 дугаар сарын 20 -ны өдөр	Байгууллагын нэр: ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: Дугаар:.....
Албан тушаалын тодорхойлолт баталсан:	
Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА Шийдвэрийн огноо: Дугаар: (тамга/тэмдэг) ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.САЙНБАЯР 20 ²⁵ оны 03 дугаар сарын 20 -ны өдөр	

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Хөдөлмөрийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Монгол Улсын Далайн захиргаа

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Нягтлан бодогч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

-

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Ерөнхий сайд А.Амарын гудамж,
Лагшан төв

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг хариуцан батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт тавин ажиллана.

Албан тушаалын зорилт:

- Байгууллагын хөгжлийн хэтийн төлөв, төсвийн төсөл таамаглал боловсруулан хянуулан, батлуулах, түүнийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих ажлыг хууль эрхийн актын хүрээнд хийж гүйцэтгэх;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагыг хангаж, байгууллагын санхүү, бүртгэлийг "Unicus" программаар хийж, хагас жил, жилийн эцэст санхүүгийн тайлан, мэдээг гаргаж, хуулинд заасан хугацаанд тайлагнах;
- Орлого зарлагын тооцоог холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй болон ажиллагсадтай хийж, тооцоо нийлэн өр авлага үүсгэхгүй, мөнгөн хөрөнгө материалын зарцуулалт, өмчийн ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллах;
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх, удирдлагаас өгсөн үүрэг,

даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, биелэлтийг хугацаанд нь тайлагнах, мэдээллээр шуурхай хангаж ажиллах, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;
5.Хууль тогтоомжид заасан бусад.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын хэтийн төлөв болон төсвийн таамаглалыг боловсруулж, салбарын сайд болон удирдах дээд байгууллагын холбогдох газар, хэлтэст хүргүүлэн батлуулах;	Санхүүгийн хувьд үр ашигтай ажиллаж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх боломж бүрдэнэ.	Г,Х,Ш
	2.Төсвийн сар, улирлын хуваарийг хийж, хуваарийн дагуу өөрийн орлогыг бүрдүүлэх, санхүүжилтийг авч, зарцуулах, “Шилэн дансны тухай хууль”-ийн хүрээнд байгууллагын мэдээллийг тухай бүр байршуулан олон нийтэд мэдээллэх;		Г,Х,Ш
	3.Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах.		Г,Х,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн хүрээнд санхүү, аж ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж үнэн зөв, бодитой баримтан дээр үндэслэн тайлан балансыг гаргах;	Байгууллагын тайланг хугацаанд нь гаргаснаар ямар үр дүнд хүрсэн, нөөцийг яаж бүрдүүлж, зарцуулсан зэрэг байгууллагын бүх санхүүгийн үйл ажиллагаа ил тод болно. “Unicus” санхүүгийн программаар ажилласнаар цаг хугацаа, хөдөлмөр хэмнэгдэнэ.	Г,Х,Ш
	2.Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн орлого, зарлагын мэдээг сар бүр, улирал, жилийн тайлан балансыг улирал тутам үнэн зөв гарган баталгаажуулж, холбогдох хавсралтын хамт удирдах дээд байгууллагын холбогдох газар, хэлтэст хугацаанд нь хүргүүлэх;		Г,Х,Ш
	3.Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг мөрдөн ажиллах;		Г,Х,Ш

	4.Аудитын дүгнэлт гаргасан тайланг удирдах дээд байгууллагын холбогдох газар, хэлтэст төсвийн тухай хуулинд заасан цаглабарын хугацаанд нэгтгүүлэх; 5.Байгууллагын тайланг санхүүгийн хувьд үр ашигтай, үр төлбөргүй, авлага, өглөггүй тайлагнах.		Г,Х,Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1.Батлагдсан орон тоог нарийн баримтлан ажилчдын цалин хөлс болон тэтгэвэр тэтгэмж, урамшууллыг цаг хугацаанд нь тавьж олгохоос гадна нийгмийн даатгалын дэвтрийн бичилтийг сар тутам хийж баталгаажуулах; 2.Үндсэн хөрөнгө болон хангамжийн материал, мөнгөн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, мөнгөн хөрөнгө, бараа материалыг үрэгдүүлэх шамшигдуулах явдалтай тэмцэж, эд хөрөнгийн тооллогыг зохих заавар журмын дагуу явуулж үр дүнг тооцон ажиллах; 3.Мөнгөн хөрөнгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж, мөнгөн хөрөнгө, бараа материал, тайлан баланс, өр төлбөрийн холбогдолтой санхүүгийн материалыг архивын заавар, дүрмийн дагуу эмхлэн цэгцэлж, дараа оны 1 дүгээр улиралд багтаан архивт шилжүүлэх; 4.Нийгмийн даатгал, татварын байгууллагуудтай сар, улирал тутам тооцоо нийлж, төлбөл зохих хугацаанд нь шилжүүлж, баталгаажуулан ажиллах; 5.Ажилтнуудыг шагнаж урамшуулах, арга хэмжээ авах талаар санал боловсруулж, дэмжлэг үзүүлэх; 6.Хөлөг онгоцны бүртгэлтэй холбоотой нэхэмжлэхийг хянаж, санхүүгийн программд шивж орлогын мэдээг сар бүр тулгаж баталгаажуулж байх;	Ажиллагсдын нийгмийн баталгаа хангагдаж, байгууллагын хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт сайжирч, ажиллагсадтай цалин, нийгмийн даатгалын тооцоо хийж үндсэн үйл ажиллагааны орлогыг сар сард нь авч байх, улсын төсвийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хуваарийн дагуу төвлөрүүлэхэд хяналт тавих болон бусад орлого зардлыг цаг хугацаанд нь тайлан бүртгэлд тусгасан байна.	Г,Х,Ш

	7.Байгууллагын удирдлагыг санхүү, бүртгэл, тооцоотой холбоотой үнэн зөв мэдээллээр хангах.		
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн талаарх мэдлэгээ байнга дээшлүүлж холбогдох сургалт, арга хэмжээнд идэвхтэй оролцох;	Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан байна.	Г
	2.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрмийн хэм хэмжээ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх ажилд идэвхтэй оролцож, байнга мөрдөж ажиллах;		Г
	3.Ажлын байр болон албан томилолтын хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж мөрдөж хэвших, удирдлагаас зааварчилгаа авч ажиллах;		Г
	4.Удирдах дээд байгууллагын тогтоол, шийдвэр, сайд, төрийн нарийн бичгийн дарга зэрэг удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, мэдээллээр шуурхай хангаж ажиллах;		Г
	5.Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг олон нийтэд үнэн зөвөөр түгээн сурталчлах.		Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Нягтлан бодох бүртгэл /041101/, Эдийн засаг /031101/		
Мэргэшил	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад тэнцсэн байх		
Туршлага	Мэргэжлээрээ 3-с дээш жил ажилласан байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; -Салбарын чиглэлийн судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан санал, бодлогын зөвлөмж боловсруулах; -Албан үүргээ гүйцэтгэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.	

	Асуудал шийдвэрлэх	-Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх -Эрхлэх асуудлын чиг үүргийн хүрээнд шийдвэрийн хувилбарыг боловсруулж, танилцуулах -Тулгамдаж буй асуудлаар судалгаа хийж, дүнг танилцуулах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах -Бусадтай итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг харилцан бий болгох
	Бусад	-Шаардлагатай нөхцөлд хариуцсан ажил үүргийн хүрээнд хэрэгжүүлж болохуйц удирдлагаас өгсөн ажлыг гүйцэтгэх -Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах -Компьютерын хэрэглээний программ, интернэт, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай байх -Мэдээллийг ажилтнуудад тэгш хүргэх -Харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх -Албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар англи хэл, бусад гадаад хэлээр мэдээллийн эх сурвалж ашиглах чадвартай байх -Нягт нямбай байх -Ёс зүйн хэм хэмжээг сахидаг байх -Ажлын ачаалал дааж ажиллах чадвартай байх -Өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Далайн захиргааны дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-

Бусад харилцах субъект:

- 1.Зам, тээврийн яам;
- 2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
- 3.Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
- 4.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага;
- 5.Бусад.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

..... Т.МӨНХБАЯР

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20¹⁵ оны ⁰⁸ дугаар сарын ²⁰ -ны өдөр

Байгууллагын нэр:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:

Дугаар:.....

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.САЙНБАЯР

20¹⁵ оны ⁰⁵ дугаар сарын ¹² -ны өдөр

---oOo---

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

☒ Байгууллагын бүтэц зохион байгуулалт шинэчлэн батлагдсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Хөдөлмөрийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Монгол Улсын Далайн захиргаа

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан
ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

-

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Ерөнхий сайд А.Амарын гудамж,
Лагшан төв

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын олон улсын байгууллагуудтай тогтоох харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх замаар техникийн туслалцаа авах, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:


- 1.Олон Улсын Далайн байгууллага (ОУДБ) болон бусад олон улсын байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг дипломат ёс зүйд нийцүүлэн зохион байгуулах;
- 2.Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэтийн төлөвийг тодорхойлох, удирдлагыг мэдээллээр хангах;
- 3.Гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж байгаа сургалт, уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийн хэлэлцэх асуудлын төслийг боловсруулж, удирдлагад танилцуулах;
- 4.Салбарын үндэсний боловсон хүчнийг гадаад орнуудад бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах;
- 5.Хууль тогтоомжид заасан бусад.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Олон Улсын Далайн байгууллагыг (ИМО) хариуцан ажиллах, гадаад орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хоёр болон олон талт хамтын ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлж, туршлага судлах боломжийг эрэлхийлэх;	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсэн байдал, үр дүн гарсан байна.	Г
	2.Гадаад орнуудын ижил төстэй байгууллага болон олон улсын байгууллагуудтай далайн болон усан замын тээврийн салбарт хамтран ажиллах санал тавьж, шийдвэрлүүлэх;	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсэн байна.	Г
	3.Гадаад орнуудад суугаа Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газруудтай хамтарч ажиллах, тэдгээрийг салбарын талаарх мэдээллээр хангах;	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсэн байдал, үр дүн гарсан байна.	Г
	4.Олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн, семинар болон сургалтуудад байгууллагыг төлөөлж оролцох, холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулахад дэмжлэг үзүүлж ажиллах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.	Г
	5.Салбарын хэмжээнд хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.	Г

2 дугаар зорилтын хүрээнд	1.Хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, удирдах дээд шатны байгууллагаас санал авах, хэлэлцээнд оролцох, уг баримт бичгийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Боловсруулсан төслийн тоо.	Г,Х
	2.Гэрээ, эрх зүйн баримт бичгийн бүртгэл хөтлөх, архивын нэгж үүсгэх;	Бүртгэл үүсгэсэн байна.	Г
	3.Дэлхий нийтийн тээврийн нэгдсэн мэдээллийн системийн хариуцан ажиллах (GISIS) системд мэдээлэл оруулах шаардлагатай мэргэжилтнүүд холбогдох мэдээллийг тогтмол оруулж, шинэчилж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын удирдлагуудын гадаад орнуудад хийх айлчлалын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;	Айлчлал хийсэн тоон мэдээлэл.	Г,Х
	2.Гадаад айлчлалтай холбоотой тайлан мэдээг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхэд удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллах.	Тайланг хүргүүлсэн тоо.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Салбарын үндэсний боловсон хүчнийг гадаад орнуудын мэргэжлийн их, дээд сургуулиудад бэлтгэх боломжийг эрэлхийлж ажиллах;	Материалыг хүргүүлсэн тоо.	Г,Х
	2.Гадаад орнуудын далайн салбарын их, дээд сургуулиудтай хамтран ажиллах талаар санал боловсруулах, хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах зэргээр хамтын ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	Санал боловсруулсан тоо.	Г
	3.Хамтын ажиллагаатай их, дээд сургуулиудад суралцуулах оюутнуудыг сонгон шалгаруулах ажлыг холбогдох сургуулиудтай хамтран зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх.	Хамтарсан тоо.	Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан ажлын чиглэлээр жил бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах,	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, үнэлгээ	Г
	2.Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний орчуулгыг хянах, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг өгч ажиллах;	Орчуулгыг хянасан тоо.	Х

	3.Хийж буй ажлынхаа талаар тухай бүр удирдлагад танилцуулан, үүрэг чиглэл авч, ажлын биелэлт, үр дүнг танилцуулах;	Үүрэг даалгаврын биелэлт.	Г
	4.Байгууллагын цахим шууданг тогтмол шалгах, ирсэн захидлыг удирдлагад танилцуулах, шийдвэрлэлтэд хяналт тавьж хариу арга хэмжээ авах;	Хариу хүргүүлсэн тоо.	Г
	5.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрмийн хэм хэмжээ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх ажилд идэвхтэй оролцож, байнга мөрдөж ажиллах;	Хууль тогтоомжид нийцсэн байна.	Г,Х
	6.Төрийн албан хэрэг хөтлөлтийг цаасан болон цахим хэлбэрээр хөтлөх, боловсруулалт, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хийж хэрэгжүүлж ажиллах;	Архивын баримт үүсгэсэн тоо.	Г,Х
	7.Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Оролцсон арга хэмжээний тоо.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх		
Мэргэжил	Олон улсын бизнесийн удирдлага /041602/, Олон улсын харилцаа /031202/		
Мэргэшил	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад тэнцсэн байх		
Туршлага	Мэргэжлээрээ 3-оос доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Англи хэлний болон бусад гадаад хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай байх; -Албан үүргээ гүйцэтгэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах -Салбарт тулгамдсан асуудал, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах; -Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, оновчтой шийдвэр гаргах чадвартай байх -Өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх эрмэлзэлтэй байх	
	Асуудал шийдвэрлэх	-Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; -Албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах.	

	Багаар ажиллах	-Өөрийн мэргэжлийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох, эерэг уур амьсгал бүрдүүлэх; -Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд хамт олноо манлайлах; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Баг, хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; -Байгууллага, хэлтсийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиглэлээр баг, хамт олонтой хамтарч ажиллах; -Өөрийн үйл ажиллагаанд шинэлэг санааг нэвтрүүлэх, бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; -Саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах.
	Бусад	-Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -Мэдээллийн орчин үеийн технологийг ашиглах, шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх; -Зам, тээврийн салбарын өөрчлөлт, шинэчлэлтийг нэвтрүүлэх, салбарын хэмжээнд зохион байгуулах мэдлэг, чадвартай байх; -Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байдлаараа манлайлах -Бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх; -Харилцааны соёлтой, ёс зүйтэй байх; -Хамт олны саналыг сонсох, санал солилцох, эргэх холбоотой байх; -Бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх.
IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Далайн захиргааны дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга		
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн.	Бусад харилцах субъект: 1.Зам, тээврийн яам; 2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс; 3.Олон улсын байгууллага, Элчин сайдын яамд, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; 4.Төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага; 5.Бусад.	
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:	

<u>Албан тушаал:</u> ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Т.МӨНХБАЯР (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20²⁵ оны 03 дугаар сарын 20-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u>.....
Албан тушаалын тодорхойлолт баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг)  ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.САЙНБАЯР 2025 оны 03 сарын 20 өдөр	

---oOo---

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:



Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан



Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Хөдөлмөрийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо

Байгууллагын нэр:

Монгол Улсын Далайн захиргаа

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

-

Ажлын цаг

Ажлын 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Ерөнхий сайд А.Амарын гудамж,
Лагшан төв

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллагын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаад арга хэмжээг дипломат ёс зүйд нийцүүлэн зохион байгуулах, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
2. Гадаадын төлөөлөгчдийг хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулах;
3. Байгууллагын ажилтнуудыг гадаад хамтын ажиллагааны хүрээнд сургалт, уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт хамрагдах ажлыг удирдлагын өгсөн чиглэлийн дагуу зохион байгуулах;
4. Хууль тогтоомжид заасан бусад.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Гадаад орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хоёр болон олон талт хамтын ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлж, туршлага судлах, боломжийг эрэлхийлэх;	Хамтын ажиллагаа өргөжин хөгжсөн байна.	Г
	2.Гадаад орнуудын ижил чиг үүрэг бүхий байгууллага болон олон улсын байгууллагуудтай далайн болон усан замын тээврийн салбарт хамтран ажиллах санал тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;	Хамтын ажиллагаа өргөжин хөгжсөн байна.	Г
	3.Холбоо тогтоосон гадаад орнуудын ижил төстэй байгууллага болон олон улсын байгууллагуудтай байнгын харилцаатай ажиллах;	Тогтоосон харилцаанд ахиц гарч, өргөжин хөгжсөн байна.	Г
	4.Олон улсын хурал зөвлөгөөн, семинар болон сургалтуудад холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулахад дэмжлэг үзүүлж ажиллах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.	Г
	5.Гадаад орнуудаас ирүүлсэн баримт бичиг, албан захидал, мэдэгдлийг холбогдох хэлтэс, алба, нэгжид хүлээлгэн өгч, хариуг тогтоосон хугацаанд хүргүүлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн.	Г
	6.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн орчуулгыг хийж гүйцэтгэх.		
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын удирдлагуудын гадаад орнуудад хийх айлчлалын бэлтгэлийг хангаж ажиллах;	Албан айлчлалын бэлтгэл бүрэн хангагдсан, үр дүн гарсан байна.	Г
	2.Гадаад айлчлалтай холбоотой тайлан мэдээг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэхэд удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллах;	Арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, дипломат ёс жаягт нийцүүлэн зохион байгуулсан байна.	Г

	3.Гадаадын зочид, төлөөлөгчдийг хүлээн авах ажлыг төлөвлөх, төлөөлөгчдийг хүлээн авах, үдэх зэрэг ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа арга хэмжээг зохион байгуулах, айлчлалтай холбоотой тайлан мэдээг удирдлагад танилцуулах;	Арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, дипломат ёс жаягт нийцүүлэн зохион байгуулсан байна.	Г
	4.Гадаад орнууд, олон улсын байгууллагуудтай хийх хэлэлцээр, уулзалт, хурал, бусад арга хэмжээг зохион байгуулахад оролцох, уулзалтын ярианы тэмдэглэл хөтлөх, холбогдох албан тушаалтан, байгууллагад хүргүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г
	5.Ажилтнуудын гадаад томилолт, хурал, зөвлөгөөнд оролцох арга хэмжээг зохион байгуулах.	Бэлтгэл бүрэн хангагдсан, үр дүн гарсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Салбарын боловсон хүчнийг гадаад орнуудын мэргэжлийн их, дээд сургуульд мэргэшүүлэх, чадавхижуулах боломжийг эрэлхийлж ажиллах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Г
	2.Гадаад орнуудын далайн салбарын их, дээд, сургуулиудтай хамтран ажиллах талаар санал боловсруулах, хамтын ажиллагааны баримт бичгийн төслийг боловсруулах зэргээр хамтын ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Г
	3.Гадаад хамтын ажиллагааны хүрээнд олон улсын төсөл, хөтөлбөрөөр ажилтнуудыг урт богино хугацааны сургалт, айлчлалд хамруулах ажлыг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хариуцсан ажлын чиглэлээр жил бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах, тогтоосон хугацаанд тайлагнах, үр дүнг үнэлүүлж дүгнүүлэх;	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, үнэлгээ	Г
	2.Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг хугацаанд нь, чанартай, шуурхай гүйцэтгэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Г

	3.Байгууллагын цахим шууданг тогтмол шалгах, ирсэн захидлыг удирдлагад танилцуулах, шийдвэрлэлтэд хяналт тавьж, хариу арга хэмжээ авах, удирдлагыг холбогдох нэмэлт мэдээллээр хангах;	Удирдлагыг мэдээллээр хангаж хариу арга хэмжээг авсан байна.	Г
	4.Эрхэлсэн ажлын хүрээнд бий болсон баримт бичгийн хөтлөх, хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж албан хэрэг бүрдүүлэн байгууллагын архивд шилжүүлэх;	Архивд материалыг тогтоосон хугацаанд хүлээлгэн өгсөн байна.	Г
	5.Ажил төрлийн холбогдолтой хурал, сургалт, семинар, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Оролцсон арга хэмжээний тоо.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
Мэргэжил	Олон улсын харилцаа /031202/, Гадаад хэлний орчуулагч /023101/, Олон улсын эрх зүй /042102/
Мэргэшил	Англи болон бусад хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх
Туршлага	-

Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Баримт бичгийн үнэн зөв, хэл зүй, утга найруулга, үг үсгийн алдааг хянаж нягтлах; -Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Шаардлагатай асуудлаар судалгаа хийх, үр дүнг хариуцах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг, чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах; -Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; -Багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; -Бусадтай харилцан итгэлцэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Англи хэлний ахисан болон бусад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх; -Өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлах, бусдын санал, бодлыг нь сонсох; -Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; -Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; -Компьютерын өргөн хэрэглээний программуудыг ашиглах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Далайн захиргааны дарга, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-

Бусад харилцах субъект:

- 1.Зам, тээврийн яам;
- 2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
- 3.Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
- 4.Гадаад харилцааны яам;
- 5.Олон Улсын Далайн Байгууллага;
- 6.Бусад.


V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Т.МӨНХБАЯР

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20~~25~~ оны ~~03~~ дугаар сарын ~~20~~ -ны өдөр

Байгууллагын нэр:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:

.....

Дугаар:.....

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГАА

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧБ.САЙНБАЯР

901000812
ТУ32111111 5202516
20~~25~~ оны ~~03~~ дугаар сарын ~~20~~ -ны өдөр

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Хөдөлмөрийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо

Байгууллагын нэр:

Монгол Улсын Далайн захиргаа

Нэгжийн нэр:

Захиргаа, удирдлагын хэлтэс

Албан тушаалын нэр:

Дотоод үйл ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

-

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Ерөнхий сайд А.Амарын гудамж,
Лагшан төв

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцан ажиллах, хэлтсийн даргын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах.

Албан тушаалын зорилт:

- 1.Байгууллагын дотоод журмын хэрэгжилт, хөдөлмөрийн оновчтой зохион байгуулалтыг хангах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах;
- 2.Байгууллагын соёлыг дээшлүүлэх, удирдлагуудыг мэдээллээр хангах;
- 3.Байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг ханган ажиллах;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад.



Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах;	Байгууллагын өдөр тутмын ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнаж ажиллана.	Г
	2.Дотоод журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах, тайлагнах;	Байгууллагын дотоод журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3.Байгууллагын хөдөлмөрийн оновчтой зохион байгуулалт, ажлын байрыг хөдөлмөрийн аюулгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн сайжруулах чиглэлээр санал боловсруулах, батлуулах хэрэгжилтийг хангах;	Хөдөлмөрийн оновчтой зохион байгуулалтыг хангаж ажилласан байна.	Г
	4.Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, дүрэм журмын хүрээнд зөрчилгүй ажилласан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын соёлыг төлөвшүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, соёлыг сайжруулах сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелэгдсэн байна.	Г
	3.Цаг үеийн шаардлагатай уулзалт, хурал зөвлөгөөнийг зохион байгуулах;	Хэрэгжилтийн хувь	Г
	4.Удирдах ажилтнуудын гадаад, дотоод томилолтын бэлтгэл ажлыг холбогдох газруудтай хамтран зохион байгуулах, томилолтын бүртгэл хөтлөх, тайлагнах.	Хэрэгжилтийн хувь	Г

3 дугаар зорилтын хүрээнд	1.Нийтээр тэмдэглэх баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд болон бусад шаардлагатай үед хариуцлагатай жижүүрийн хуваарь гаргаж удирдлагаар батлуулах, жижүүрээр томилогдсон ажилтнуудад холбогдох мэдээллийг өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;	Байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг ханган ажиллана.	Г
	2.Уулзалтын өрөөнд зохион байгуулагдах уулзалт хурал, зөвлөгөөний захиалгыг хүлээн авах, бүртгэлд оруулах, хяналт тавих.		Г,Х
	3.Баяр ёслол, тэмдэглэлт ой, үйл явдлыг зохих журмын дагуу зохион байгуулах.		Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Байгууллага, салбарын дунд зохион байгуулах спорт арга хэмжээг зохион байгуулах;	Хэрэгжилтийн хувь	Г,Х
	2.Ажилтнуудаас ажлын байрны нөхцөл, өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээтэй холбогдуулан гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;		Г,Х
	3.Байгууллагын гадна талын болон дотоод орчны тохижилт үйлчилгээнд хяналт тавих;		Г,Х
	4.Байгууллагын албан утсыг хариуцах, харилцагчийг үнэн зөв мэдээллээр хангах.		Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	Багш, мэргэжлийн /0113, 0114/, Гадаад хэлний орчуулагч /023101/, Менежмент /041303/	
Мэргэшил	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад тэнцсэн байх	
Туршлага	Мэргэжлээрээ 1-с доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; -Салбарын чиглэлийн судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан санал, бодлогын зөвлөмж боловсруулах; -Албан үүргээ гүйцэтгэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Асуудал шийдвэрлэх	-Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх;

		-Албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах -Салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох -Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; -Өгсөн мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөнийхөө үндэслэл, үнэн зөв байдлыг хариуцах; -Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу зам, тээврийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; -Бусад.
	Багаар ажиллах	-Өөрийн мэргэжлийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох, эерэг уур амьсгал бүрдүүлэх; -Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд хамт олноо манлайлах; -Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; -Баг, хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; -Байгууллага, хэлтсийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиглэлээр баг, хамт олонтой хамтарч ажиллах; -Өөрийн үйл ажиллагаанд шинэлэг санааг нэвтрүүлэх, бусдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих; -Саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;
